

## Монголын уламжлалт боловсролын философи

Долгосүрэнгийн Дулмаа, *магистр*  
Хүүхдийн эрхийг хамгаалах “Яруу” төв  
Улаанбаатар, Монгол Улс, [ddulmaa701@gmail.com](mailto:ddulmaa701@gmail.com)  
<https://orcid.org/0009-0008-3636-0733>

### Article history

Received : 2024-08-31  
Accepted : 2024-09-23  
Published : 2024-12-20

Түлхүүр үгс  
боловсролын  
философи,  
уламжлалт арга  
ухаан,  
нийгмийн хөгжил,  
бие хүн

### Keywords

*philosophy  
of education,  
traditional  
methods,  
social  
development,  
personality*

© The Author(s), 2024



**Хураангуй:** Өнөөдөр боловсролын философийн талаар эрдэмтдийн бүтээн туурвисан өдий төдий өөр хоорондоо зөрчилдсөн, эс зөрчилдсөн үзэл санаа, сургаал номлол, урсгал чиглэлүүд оршоор байна. Ерөнхийдөө бол боловсролын философи бол иргэн төлөвших үндсэн асуудлыг авч үзэх бөгөөд бие хүн төлөвшихөд нөлөөлөх бүхий л хүчин зүйлийг нэгдсэн цогц байдлаар авч үздэгээрээ онцлог юм. Өөрөөр хэлбэл хүн төлөвшлийн асуудалд хандахдаа зөвхөн сургууль мэдлэг олгох хэлбэр биш харин хүн өөрийн оршин буй нийгэмтэйгээ харилцан үйлчлэлцэх замаар хүмүүжиж төлөвшиж байдаг гэсэн үзэл санааг илэрхийлдэг. Манай улсын хувьд хүнээ төлөвшүүлж ирсэн уламжлалт арга ухаан, өөрийн гэсэн өвөрмөц боловсролын философитой байсан нь өвөг дээдсээс өвлөгдөж ирсэн аман болон бичгийн өв соёл, түүхэн сургааль номлол, төрийн зүтгэлтнүүдийн ном бүтээлд тусгалаа олсон нь харагдаж байна. Тухайлбал монголчууд эхэндээ нүүдлийн ахуй соёл, амьдрах орчноосоо мэдлэг, чадвар, боловсролыг эзэмшиж байсан байна

## Mongolian traditional philosophy in education

**Dulmaa Dolgorsuren (MA)**

*Child Rights Protection Center for “Yaruu”  
Ulaanbaatar, Mongolia, [ddulmaa701@gmail.com](mailto:ddulmaa701@gmail.com)  
<https://orcid.org/0009-0008-3636-0733>*

**Abstract:** Today, there are contradictory theories, beliefs and practices developed by scientists in the field of education philosophy. In general, educational philosophy takes into account the fundamental problems of the establishment of the citizen and distinguishes itself from comprehensive consideration of all variables affecting the development of the individual. In other words, the concept of human development conveys the idea that one develops and matures through interaction with society and not simply through formal education systems. It is clear that our nation has its own educational system and customs, which are reflected in the writings and oral traditions of our ancestors, historical preaching, and leaders' writings. For example, Mongolian nomadic lifestyles and cultures contribute to their education, knowledge and skills.

## I. Оршил

Сүүлийн үед онол болон хэрэглээний талаасаа амжилттай хөгжиж байгаа мэдлэгийн салбарын нэг бол боловсролын философи юм. Боловсролын философи нь боловсрол гэж юу болох, түүний зорилго чиглэл юу байх, боловсролын тогтолцоо ямар байх тухай асуудлыг товчхондоо судалдаг. Өөрөөр хэлбэл боловсролын философи нь үүсэж хөгжсөн цагаасаа өнөөг хүртэл оршиж буй боловсролын системийг судлан тайлбарлаж шинэ үзэл санаа, шинэ үнэт зүйлсийг бий болгосоор ирсэн. Манай улсын хувьд 1990-ээд оноос боловсролын философийн асуудлаар суурь судалгааны ажил эрхэлж эхэлсэн байдаг. Тухайлбал Ц.Бүжидмаа, Н.Бэгз нарын “Боловсролын философийн зарим асуудал” (Уб., 1996), Н.Бэгз “Монгол улсын боловсрол” (Уб., 1996), “Боловсрол судлалын товч ухагдахууны товч тайлбар толь” (Уб., 1994., Ш.Шагдар “Монгол улсын боловсролын түүхийн товчоон” (Уб., 2000) зэрэг бүтээлүүд нь тухайн үеийн хамгийн анхны томоохон бүтээлүүдэд тооцогдож байна.

Зохиогчийн хувьд монголын уламжлалт боловсролын философи, сурган хүмүүжүүлэх ухааны үүсэл хөгжлийн чиг хандлагын талаар судлаачдын өмнө боловсруулсан үзэл баримтлалыг тодорхой хэмжээгээр баяжуулах, онол үзэл баримтлалд дүн шинжилгээ хийж дагнан судалснаараа харьцангуй дэвшилттэй болсон гэж үзэж байна.

## II. Судалгааны арга зүй

Тус өгүүллийг чанарын судалгааны аргаар монголын уламжлалт боловсролын философийн хөгжил, цаашдын чиг хандлагын талаар

судалгаа шинжилгээ хийж сэдвийн хүрэн дэх үндсэн ойлголт, агуулга, үзэл санааг дэвшүүлэв. Мөн боловсролын философийн асуудлаарх эрдэмтэн, судлаачдын бүтээлийг ашигласан нь уг өгүүллийн онол, арга зүйн үндэс болно.

## III. Судалгааны үр дүн ба үндсэн хэлэлцүүлэг

*Боловсролын философи гэж юу вэ?* гэдэг асуултад хариулахын тулд юуны өмнө боловсролын философи хэмээх ойлголтын үндсэн нэр томьёо, ухагдахууны талаар авч үзэх нь зүйтэй. “Боловсролын философи нь боловсролын мөн чанар, зорилго, боловсролын онол, практикаас үүдэлтэй философийн асуудлуудтай холбоотой хэрэглээний болон практик философийн салбар юм. 1960-аад оноос эхлэн АНУ, Франц, Английн их сургуулиудад боловсролын философийн тэнхим, 1980-аад оноос эхлэн Оросын эрдэмтэд боловсролын философийн асуудлуудыг анхааран судлах болсон байна. Харин манай улсын хувьд 1990 –ээд оны дунд үеэс боловсролын философийн тухай ярих болсон ба энэ үеэс судалгаа хийж эхэлсэн байна.

Боловсролын философийг судлаач, эрдэмтэд дараах байдлаар тодорхойлжээ (Ичинхорлоо Ш. 2007).

о Боловсролын философи нь боловсролын тухай онолын сэтгэлгээний арга хэлбэр (Иоханнцс, Бойс).

о Боловсролын философи нь соёлын нэг институт болох боловсролын мөн чанар, үнэ цэнийн тухай түүний хөгжлийн стратегийн бодлогыг тодорхойлох эрмэлзэл бүхий үзэл бодол, эргэцүүлэл юм

(А.Г.Асмолов).

о Боловсролын үнэт зүйл гэдэг нь соёлын үнэт зүйлсийг нэг үеэс нөгөө үед өвлүүлэх тухай юм (Бафффорд, Страйк).

Боловсролын философи нь нэг талаасаа боловсролын хүрээний тухай шинжлэх ухааны төсөөллүүдийн хүмүүжлийн явцад хүн нэг бүрт төлөвшдөг ертөнцийн тухай төсөөлөл юм (Бэгз Н., Пүрэв О., Энхцогт Н, ба бусад 2012).

Боловсролын философийн урсгал чиглэл нь боловсролыг дараах байдлаар тайлбарлаж болохоор байна. Тухайлбал,

*Прагматизмын* гол төлөөлөгч нь Дж.Дью бөгөөд боловсролыг хөгжүүлэх үндсэн үзэл санаа, философи үндэслэлийг хамгийн анх дэвшүүлсэн эрдэмтэн юм. Түүнийхээр боловсрол гэдэг нь нийгмий амьдралын бүрэлдэхүүн хэсэг нийгмийг хөгжүүлэх, нийгмийн хөгжлийг хувьсгалт бус аргаар өөрчлөх арга хэрэгсэл мөн. Түүний ачаар хүн уламжлалт ёс заншил соёлын өвийг эзэмшдэг гэж үздэг. Боловсролын зорилго нь хүнд орчиндоо зохицож, нийгмийн дотор амьдрах аргыг сургах, төрөлхийн авьяас чадвараа хөгжүүлэх боломж олгох явдал хэмээн энэ чиглэлийг баримтлагчид үздэг.

*Неопрагматизмын* гол төлөөлөгчдөд А.Маслау, А.Комбс, Э.Келли, К.Роджерс нарыг дурдаж болох юм. Тэд хүний зан үйл, авьяас чадвар нь хүнд төрөхөөс заяасан байдаг. Түүнийг илрүүлж, өөрийг нь таниулж өгөхөд боловсролын зорилго оршино. Хүн зөвхөн өөрийн Би-г нээсний үндсэн дээр орчноо таньж мэдэх боломжтой болдог гэж үздэг. Хүний хувийн чанарууд нийгэмших

явцад илэрч хөгжинө гэж Дж.Дью үзжээ.

*Экзистенциализмын* голлох төлөөлөгчид нь Я.Ясперс, А.Грийн нар бөгөөд тэдний гол үзэл санаа нь бие хүн түүний бодгаль ахуйн тухай онол дээр үндэслэгддэг. Бодгаль ахуй бол нийгмээс хамаарахгүйгээр өөрийн дотоод мотивацаар хөгжиж байдаг бөгөөд хүний танин мэдэх, урлан бүтээх чадвар боломжийн эх булаг болдог. Боловсролын зорилго нь хүнийг өөрийгөө хүн болгон төлөвшүүлэх аргад суралцууулах явдал юм (А.Грийн). Өөрөөр хэлбэл хүнд өөрийг нь өөрийнх нь дотоод мөн чанаруудыг нээж өгөхөд боловсролын зорилго оршино гэж үздэг.

*Необихевиоризм* хэмээх энэхүү урсгал чиглэл нь экзистенциализмийн эсрэг үзлийг баримталдаг. Боловсролын зорилго нь бие хүний өвөрмөц зан чанар, авьяас чадварыг хөгжүүлэх явдал биш, харин нийгэмд зохицсон дуулгавартай иргэн төлөвшүүлэхэд оршино гэж үздэг (Долгорсүрэн Б. 2005).

*Инструменталистын* гол төлөөлөгч бол Жон Дью юм. Түүнийхээр бол нийгмийн сайн сайханд дасан зохицсон чанартай, үр ашигтай боловсролын чиг хандлагыг чухалчилж байна. Боловсролын философийн эхлэх цэг ба төв нь хүүхэд, түүний хөгжлийн асуудал асуудал юм. Боловсрол бол хүүхдийг амьдрах арга ухаантай, чадвартай болгох үйл явц мөн. Боловсролын гол зорилго бол мэдлэг олгох биш, бие хүнийг нийгэмшүүлэх явдал юм. Боловсрол бол хүнийг амьдралд бэлтгэж буй хэрэг биш, харин амьдрал өөрөө боловсрол юм” хэмээн хүний амьдралын тасралтгүй үргэлжилдэг үйл явц болохыг илэрхийлжээ.

Түүнийхээр оюун ухаан бол ойлгох зориулалт ниструмент гэж үзээд бодол санаа нь оюун ухааны телеологи зэвсэг мөн гэсэн байна. (Саулугүл М. 2012)

Дээрх боловсролын талаарх үзэл баримтлалуудыг нэгтгэн дүгнэж үзвэл Ж. Дьюгийн гол үзэл баримтлал нь боловсролыг иргэдийн соёл, хэрэгцээ сонирхолтой нь үр ашигтай байдлаар холбох хэрэгсэл мөн хэмээх инструменталист үзэл баримтлал

нь хамгийн зөв оновчтой гэж хэлж болохоор байна. Тэрээр боловсролыг иргэдийн бодит амьдралтай холбож өгөх хэрэгтэй, учир нь боловсрол бол хүн амьдралаа өөрийн хүссэнээр зохиоход туслах хэрэгсэл юм, харин хүн бодит байдлыг өөрийн хүсэл сонирхлын дагуу бүрдүүлдэг болохыг онцолсон байна.

*Хүснэгт 1. Боловсролын философийн үндсэн урсгал чиглэл нь боловсролын зорилгыг дараах байдлаар тодорхойлжээ.*

Боловсролын философийн урсгал, чиглэл	Боловсролын зорилго
<b>Прагматизм</b>	Хүний төрөлхийн авьяас чадварыг хөгжүүлэх, орчиндоо зохицох аргад сургах
<b>Неопрагматизм</b>	Хүний дотоод мөн чанарыг нээж, өөрийг нь таниулж өгөх
<b>Экзистенциализм</b>	Бие хүний өөрийн хөгжлийг хангах
<b>Необихевиоризм</b>	Нийгэмдээ зохицсон дуулгавартай хүн төлөвшүүлэх
<b>Инструменталист</b>	Боловсролын гол зорилго бол мэдлэг олгох биш, бие хүнийг нийгэмшүүлэх

Дээрх урсгал чиглэлийг баримтлагч эрдэмтэд нь боловсролын зорилгыг тодорхойлохдоо нэгдмэл үзэлтэй байна. Хэдийгээр боловсролын философийн олон урсгал чиглэл бүр нь өнгөц харахад бие биетэйгээ эсрэг тэсрэг мэт боловч боловсролыг тайлбарлах цаад мөн чанар нь ижил төсөөтэй байгаа нь харагдаж байна.

XX зуунаас өмнө үеийн монголчуудын уламжлалт боловсрол түүний философи үндэслэл бол монголчуудын хүн төлөвшүүлэх арга ухаан болсон боловсролын философийн түүх нь өөрийн гэсэн онцлог шинж, түүхэн тодорхой бүтэцтэй билээ. Өөрөөр хэлбэл монголчуудын хүн төлөвшүүлэх философи сэтгэлгээний бүтцийг дараах байдлаар хуваан үзэж болдог. Үүнд:

1. *Нүүдэлчин монголчуудын өдөр тутмын амьдрал, эмпирик туршилагад үндэслэсэн хүн төлөвшүүлэх философи үндэслэл: (Энэ нь бусад элементүүдийнхээ суурь үндэслэл болж өгнө)*
2. *Ардын сурган хүмүүжүүлэх зүйн хүрээн дэх хүн төлөвшүүлэх арга технологи*
3. *Боловсролын тухай онолын үзэл баримтлалууд*
4. *Буддын шашны боловсрол (шашны философи дахь бие хүний төлөвшилийн асуудал)*

Нэгдүгээр бүтцийн талаар авч үзвэл, түүхийн энэ үед монголчууд малаа дагаж, түүнийхээ шим буянаар амьдралынхаа бүхий л хэрэгцээг хангадаг байсан үе юм. Өөрөөр хэлбэл тэдний боловсролыг олж авах

хэрэгцээ нь цөм тэдний нүүдэлчин ахуйгаар тодорхойлогдож түүнийхээ хүрээнд багтаж байсан гэхэд болно. Өөрөөр хэлбэл амьдралд шаардагдах бүхий л мэдлэг, боловсрол, дадлага, туршлагыг амьдралын орчноосоо эзэмшиж байсан тул тэдний өдөр тутмын амьдрал нь өөрөө бүхэл бүтэн сургууль болж таарч байгаа юм. Энэ үеийн монголчуудын хүнээ хөгжүүлэх философи сэтгэлгээний онцлог нь хүнийг байгаль-нийгэм, системийн гишүүн болохынх нь хувьд түүнд тогтсон ёсонд нийцүүлэн засаж хөгжүүлэх хэлбэрээр хөгжсөнд оршино. Үүнээс үүдэн засахуйн билиг сургаал бүрэлдэн тогтсон байна. (Дорж Д. 1998)

Энэхүү “Засахуйн билиг сургаал” нь төрийг засахуй, цэргийг засахуй, эрдэмтэн мэргэд, нөхрийг засахуй, бие сэтгэлийг засахуй хэмээн ангилагддаг байна. Монголчуудын “засахуйн билэг сургаал”-ыг төрийг засахуй, цэргийг засахуй, эрдэмтэн мэргэд, нөхрийг засахуй ба бие сэтгэлийг засахуй гэж ангилан авч үздэг байна. Монголчуудын «биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас» гэсэн билэг сургаал нь засахуйн сургаалийн товч илэрхийлэл бөгөөд тодорхой, нийгэм, улс үндэстэн, овгийн хүрээнд тогтсон ёсонд нийцүүлэх хувь хүн өөрийгөө болон бусдыг засах ёстойг илэрхийлдэг байна. Үүнээс үзэхэд монголчуудын хүнээ төлөвшүүлж, хөгжүүлдэг эмперик туршлагаас үүдсэн мэдлэг нь хүнийг байгаль экологийн нэгэн хэсэг болохын хувьд түүнийг хамгаалан хөгжүүлж, түүний хүрээнд өөрөө хөгжиж дэвшдэг философи сэтгэлгээнд үндэслэсэн байна.

*Монгол нүүдэлчин амьдралын учир:* Хүн төрөлхтэн адгууснаас

ялгаран ухаант хүн болсон үеэс эхлэн эхэндээ амьтны адил байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг ашиглаж амьдрах арга нь хэвээр байснаа нэгэнт ухамсраар зохицуулах нөхцөл бүрдсэн учир амьдрах аргаа сайжруулах эрлийн их замд таарчээ. Үүний үр дүнд байгалийн ургамлыг түүж боловсруулахаас тарьж ашиглах аргад шилжих буюу газар тариалан эрхлэх, суурьшин амьдрах, зэрлэг ан амьтныг агнаж хэрэглэхээс гаршуулан тэжээж түүгээр дамжуулан байгалийн өгөөжийг ашиглах аргад шилжих буюу амьдрах гэсэн үндсэн хоёр эрдэмтэд судлан тогтоожээ.

Амьдралын эдгээр хэв маягаа дагаад суурьшмал ба нүүдлийн гэж нэрлэгддэг ба зонхилох хоёр соёл иргэншлийг бүтээн хөгжүүлсэн бөгөөд эдгээр нь нийгмийг адгууснаас тасарсан хүний ухамсараар зохицуулагдах өвөрмөц зохион байгуулалт, бүтэцтэй сүргийн популяцийн амьдрал гэж болно/ түүхийн урт хугацаанд хэрхэн солигдож, харилцан нөлөөлж хөгжсөн тухай асуудал шинжлэх ухаанд өнөөдрийг хүртэл нэг мөр ойлголтонд хүрч шийдэгдээгүй, олон янзын үзэл онол таамаглалын түвшинд байна.

Энэ бүгдийн зохистой бүрдэл нь монголчуудад байгалийн шалгарлын оюун ухаанаараа даван зохицуулж таван хошуу талаа өсгөн нүүдэллэн амьдарч хамгийн бага хүч зардлаар хэрэгцээгээ хангах аргыг олох үүнээс ургуулан өөрийн өнгө төрхтэй аж төрөх ёс, соёлыг бүтээх шаардлага үүссэн байна. Олон зууны туршид тийн шалгагдсан өөрсдийн нүүдэллэн амьдрах өвөрмөц хэв маягийг бий болгон өнөөг хүргэжээ. Жишээ нь: Манай ард түмний гайхамшиг мөн монгол нүүдэлчин гэж хэн бэ? Г.Сүхбаатар, М.Гонгоржав, Н.Эрдэнэцогт зэрэг судлаачдын үзлээр

өрнө дорны хоёр соёл иргэншлийн хүчтэй нөлөөг аван өргөн уудам нутагт байгаль хүн мал гурвын зохистой хослолыг илэрхийлсэн нүүдлийн сонгодог мал аж ахуйг амьдрал соёлынхоо үндсэн булаг болтол хөгжүүлээд цагийн шалгарлыг баттай даван туулж, өнөө хүртэл хөгжүүлж авчирсан хүн төрөлхтний нэгээхэн хэсэг хүний амьдралын хоёр үндсэн хэв маягийн нэг болох нүүдлийн соёл иргэншлийг цогцоор хөгжүүлж хадгалж ирсэн ард түмэн мөн гэж үзсэн байна. Дээрх асуултын хариуг хүний хөгжил боловсролын утгаар авч үзвэл манай өвөг дээдэс нүүдэллэн аж төрөх түүхэндээ эдийн ба утга соёлын арвин өвийг залгамжлан хөгжүүлж ирсэн нь монгол хүн бүр оролцох эрдмийн чадах зүйлсийг хамтад нь багтаасан монголчуудын эрдэм хэмээх ойлголтын өргөн утгыг үндэслэн цогцолбор болгосон өнөөдрийн монгол хүний агуулгын гол цөм үндэс нь байх ёстой юм.

Монгол нүүдэлчид олон зууны туршид мал аж ахуйг сонгодог хэлбэрээр эрхлэн амьдарч түүх соёлын нугачаанд бүдрэлгүй ирсний гол нууц нь Төв Азийн нутагт тохирсон нүүдэллэн аж төрөх ёс нүүдлийн соёл иргэншлээ суурьшлын соёл иргэншлийн сайн зүйлээр зохистой баяжуулж хөгжүүлэх ухаанаар үе удмаа сурган хүмүүжүүлж чаддагт оршино. Үеэс үед өвлүүлэн үлдээх бүхэл бүтэн тогтолцоог бий болгон баяжуулж ирсэн түүхтэй бөгөөд уг тогтолцоог судлах ажлыг манай эрдэмтэд хийж байжээ. Ялангуяа монгол ардын сурган хүмүүжүүлэх уламжлалын хүрээнд ардын аман ба бичиг сургаалын зохиол, ёс заншилд шингэсэн үзэл санааг шинжлэх ухааны үндэстэй тайлбарлах талаар түлхүү

судалсны дотроос Ж.Лувсандорж, Ш.Гаадамба, Ш.Сүхээ, Б.Бор нарын олон эрдэмтдийн хувь нэмрийг дурьдаж болно. Гэхдээ монгол уламжлалыг нүүдэлчний язгуур соёлын өвтэй холбон судлан тогтоох асуудал бараг орхигдсон учраас одоо болтол монголчуудад өөрийн гэхээр сурган хүмүүжүүлэх арга ухаан байхгүй гэсэн ойлголт, бодол санаа газар авах шинжтэй.

Үүнээс улбаалан монгол угсаатны тэр дундаа монгол нүүдэлчний сурган хүмүүжүүлэх арга тогтолцоог шинжлэх ухааны түвшинд судлан боловсруулж өөрийн өвөрмөц нөхцөл нийгмийн хөгжлийн хэтийн зорилго монгол хүүхдийн ухаан чадварт нийцсэн сурган хүмүүжүүлэх ухааныг манайд одоо хүртэл боловсруулж амжаагүй байна. Харин оронд нь бусдын жинхэнэ суурьшмал амьдралын боловсрол эзэмшүүлэх аргыг бэлнээр авч түгээх онолын баримтлал гэж үзээд нэвтрүүлэхийг оролдох өрөөсгөл хандлага байгааг шүүмжлэн үзэх шаардлагатай. Үүнд: онгон байгаль, таван хошуу мал, хот айл саахалтаар хамтран аж төрөх харилцаа, хамтран хөдөлмөрлөх уламжлал, бэлчээрээр мал маллах уламжлалт ухаан, малчин айлын гэр бүл дэх харилцаа, ардын оюун, бичгийн өв уламжлал зэргийг хамруулж болно. Эдгээр хүчин зүйлүүд нь өөр өөрийн бие сэтгэхүйн онцлог хөгжлийг бий болгохын зэрэгцээ монгол хүн төлөвшин хөгжихийн зэрэгцээ монгол хүн төлөвшин хөгжихийн хамгийн гол үндэс мөн гэлтэй байна.

Ардын сурган хүмүүжүүлэх сурган хүмүүжүүлэх зүйн хүрээн дэх хүн төлөвшүүлэх арга технологи: Үүнд үндэсний ардчилсан хувьсгалаас өмнөх үе хамаарах бөгөөд сурган

хүмүүжүүлэх арга зүй нь дотроо дараах бүтэцтэй байна. Тухайлбал:

- о Байгал орчноор дамжин хүмүүжүүлж ирсэн туршилага-байгалиар хөгжүүлэх зарчим*
- о Эрүүл чийрэг өсөхийн тулд анхаарч ирсэн туршилага- эрүүл мэнд, бие бялдарын боловсрол*
- о Ажил хөдөлмөрт сургаж ирсэн туршилага- хөдөлмөрийн хүмүүжил*
- о Малд хайртай, энэрэнгүй ханддаг, ахмад үеэ хүндэтгэдэг болгон хүмүүжүүлдэг туршилага- ёс суртахууны боловсрол*
  - Ном эрдэм сургадаг арга ухаан*
  - Оюун ухааныг хөгжүүлдэг арга*
  - Урлаг уран сайхны аргаар хөгжүүлэх арга*
  - Сайн үлгэр дууриаллаар хүмүүжүүлдэг арга* гэх мэт олон арга барил, баялаг туршлагатай байжээ.

Хүмүүжүүлэх арга нь биеэр үлгэрлэх, ухамсарлуулан зөвлөж сургах, итгүүлэн ятгах, шаардан захирах, дасгал сургууль хийлгэх, хэл яриаг шүүн сургах, магтаж ерөөх, шагнан урамшуулах, зэмлэн шийтгэх, хориглох, сүрдүүлэн айлгах, ичээх, шивших, учирлан гуйх гэтийн арга хэлбэрүүд байдаг бөгөөд хамгийн өргөн хэрэглэгддэг нь дараах хоёр болой.

Биеэр үлгэрлэн сургах аргад хүмүүжүүлэгч эцэг эх, төрөл төрөгсөд, айл хөршийнхний хоорондын харилцаа холбоо гол үүрэгтэй. Эрт дээр үеэс монголчууд гэр бүл овог аймаг доторх элдэв муу харилцааг жигшин, төвшин харилцааг эрхэмлэн үзсээр ирсэн. “Загас ихтэй нууранд шувуу олон зан сайтай айлд нөхөд олон. Төрсөн хүмүүс эвгүй бол түмний

шившиг” хэмээх сургаалийг санан гэр бүлийн гишүүдийн харилцаанд байнга анхаарал тавьж, өөрөө буюу өрөөл бусдыг үр хүүхэддээ үлгэрлүүлэх арга ухааныг цуцалтгүй сэдэж хэрэглэж иржээ.

Ухамсарлуулан зөвлөх нь аливаа юмны утга учир, нарийн ширийнийг ойлгуулан ухамсарлуулж, зовлон үйл ажиллагааг нь зүгшрүүлж ирсэн уламжлалт түгээмэл арга юм. Эртний судар “Алтан товч” зохиолд Гуа цэцэн Тулуйд: Хан хүний улсаа засах ёс нь наран мэт ул ялган нуур ул голон хатуужих буй гэжээ. Тулуй үүнийг ухан ядахад тэрээр ийнхүү тайлбарлаж: Ханхүү наран мэт бүү ялга хэмээх минь ургавал сайн мууд, амьд ба үхсэнд тэгш халуун гэрэл хүргэнэ. Ханхүү мэт тэгш сэтгэлтэй болбоос их улсын хайр яахин угүй болох. Нуур мэт бүү гол хэмээх минь нуурт сайн муу амьтад бүгд орно. Сайн муу бүгд усанд ороод буртаглаваас нуур тэр бүгдийг үл голон шингээнэ. Ханхүү тэр мэт сэтгэж сайн муу, үнэн худал үгийг сонсоод өдөөж хатгасан үгэнд үл орон тэгш болгон сонсвоос улс яахин эвдрэх гэжээ. Ингэж үр хүүхэддээ төдийгүй төрийн түшээгээ улсын хэргийг хөтлөн явуулахад энэ аргыг өргөн хэрэглэж иржээ.

Хүмүүжүүлэх ажлыг зохион байгуулж ирсэн уламжлал: Үүнд олон тооны зан үйл, заншил, хөдөлмөрийн баяр ёслол, наадам зэрэг орно. Хүн бүл цөөнтэй нэгэндээ нийтээр очиж туслах, эсгий хийх, унага тамгалах зэрэг томоохон ажлуудыг айл хотлоороо нийлж хийх зэрэг хамтын хөдөлмөр, харилцан туслах явдал нь аажмаар хөдөлмөрийн баярын хэлбэрээр уламжлагдан иржээ. Энэ нь ихэнхдээ дуу бүжиг, тоглоом наадмаар дуусдаг онцлогтой. Түүнээс гадна

Азийн Монгол гаралтай үндэстэн ястануудын дунд ийм хэлбэрийн үйл ажиллагаанууд өнөөг хүртэл хадгалагдан баяжиж иржээ. Жич: Татар. Чуваши, Буриадын ард түмний хавар намрын баяр, үдшийн цэнгээн тойрон бүжиг нь залуучуудын гоо зүйн хүмүүжилд онцгой нөлөө үзүүлдэг байна. Энэ үед сургууль боловсролын байгууллага нь сонгодог утгаараа бий болоогүй байсан ч (i) *өрх гэрийн сургууль*; (ii) *эх хэл, ардын аман зохиол*; (iii) *ардын урлаг, тоглоом бичгээр уламжилж ирсэн өв соёл* зэрэг нь хүмүүжлийн институтын үүргийг гүйцэтгэж байсан онцгой хэлбэрүүд юм. Эдгээрээс голлох үүрэг гүйцэтгэж байсан хэлбэр нь өрх гэрийн боловсрол ардын аман зохиол юм.

*Өрх гэрийн сургууль бол* хүн төлөвших үйл явцад нөлөөлдөггүй орчин гэж байхгүй боловч хүмүүжлийн анхны өлгий болсон өрх гэрээс эхлэн хүн гадаад орчинтойгоо танилцаж нийгэмтэй харьцаж сурдаг. Ийм учраас эрдэмтэд гэр бүлийн хүрээн дэх боловсролын асуудлыг онцгойлон судалж түүний ач холбогдлыг өндрөөр үнэлж байдаг.

Монголчуудын гэр бүлийн хүрээн дэх харилцаа нь тодорхой уламжлал, зан заншлаар нөхцөлдөж түүгээр зохицуулагдаж иржээ. Гэр бүлийн гишүүд тухайлбал эхнэр нь нөхөр үр хүүхдээ, нөхөр нь эхнэр хүүхдүүдээ хүний хувьд ихэд хүндэтгэн үзэж харилцдаг ёс бий. Гэрийн дотор тогтсон хөдөлмөрийн хуваарь байх бөгөөд эмэгтэй хүүхдийг ээж нь, эрэгтэй хүүхдийг аав нь дагуулан бага наснаас нь ажил хөдөлмөрт сургадаг уламжлал тогтжээ. Гэр бүлийн хүмүүжлийн хүрээнд ахмад хүнийг хүндэтгэх, байгаль дэлхий, уул ус, гал голомт мал сүргээ хайрлан хамгаалж хөгжүүлэх,

найз нөхөд бусад хүмүүстэй эвтэй найртай хандаж шулуун шударга, үнэнч зан чанарыг эрхэмлэхийн чухлыг байнга сургаж зөвлөн ийм ухамсар, сэтгэлгээ төлөвшүүлэхийг зорьдог байжээ. Өөрөөр хэлбэл өрх гэрийн боловсрол гэдэг нь өрхийн гишүүдийн харилцаа, тэдний зан заншлаар уламжлан гэр бүлийн хүрээнд бие хүн төлөвших үйл явц бөгөөд нөгөө талаас өрхийн насанд хүрэгчдээс айл гэрийн амьдралын хэвшлээр дамжуулан хүүхдийн боловсрол, төлөвшилд үзүүлэх нөлөөллийг хэлэх бөгөөд энэ нь хүүхдийг амьдралд сургах, нийгмийн харилцаанд бэлтгэх гэсэн эцэг эхийн эрмэлзлээс үүдэн яваандаа тодорхой чиглэл зорилго систем, дэс дараалалтай болжээ. Боловсролын байгууллага сонгодог утгаараа бий болоогүй байсан тэр үед чухамдаа гэр бүл л боловсролын институтын үүргийг гүйцэтгэж гэр бүлийн хүрээнд бие хүн төлөвшихөд зайлшгүй шаардлагатай мэдлэг чадвар дадлыг эзэмшүүлж ирсэн байна.

Боловсролын тухай онолын үзэл баримтлалуудын үүднээс авч үзвэл, үр хүүхдээ хүмүүжүүлэх, иргэн болгон төлөвшүүлэх процесс нь нийтийн нэг салшгүй хэсэг тул энэ үеийн эрдэмтэн судлаачид сургууль байгуулах оролдлогыг хийж байжээ. XVIII-XIX зууны үеийн боловсролын философийн онолын сэтгэлгээнд чухал хувь нэмэр оруулж, ардын үр хүүхдийг сурган хүмүүжүүлэх их үйлдсэд зүтгэж байсан гол эрдэмтэд бол Агваандандар, То ван Тогтохтөр, Агваанхайдав, В.Инжиннаш нар болно.

Харин буддын шашны боловсрол /шашны философи дахь бие хүний төлөвшлийн асуудал: Монголчуудын өөрийн унаган шашин бол бөө мөргөл



боловч бурханы шашин дэлгэрснээс хойш нийгмийн ихэнхи хувийг хамарч улмаар ХХ зууны эхэн үед монголын нийт эрэгтэйчүүдийн 70 хувь нь лам болж байжээ. Буддын шашны философи дахь бие хүн төлөвшлийн асуудал бөөгийн шашинтай харьцуулахад түлхүү хөгжиж онцгой нөлөөтэй байсан гэж хэлж болно (Долгорсүрэн Б. 2005).

#### IV. Дүгнэлт

Боловсролын философи нь нэгдүгээрт орчин үеийн шинжлэх ухааны төвшинд хөгжсөн салбар ухаан хоёрдугаарт эрт үеэс өнөөг хүртэл дараа дараагийн буюу хойч үеэ сурган хүмүүжүүлж, амьдралд бэлтгэхдээ баримталж ирсэн хүн төлөвшлийн үзэл санааны ерөнхий чиг хандлага гэсэн хоёр утгаар хэрэглэж болохоор байна. Хоёр дахь утгаараа бол хүн төрөлхтөн үүссэн үеэс эхлэлтэй бөгөөд харин шинжлэх ухааны түвшинд 20 зууны 40-өөд оноос яригдаж ирсэн байдаг. Түүний үүсэл хөгжлийн түүхийг судлан зорилго судлагдахууныг нь авч үзвэл боловсролын философи нь нэг талаасаа “хүн төлөвшлийн гүн ухаан” нөгөө талаасаа иргэн төлөвшлийн үйл явцыг судалдаг шинжлэх ухаан болж байгаа юм.

Монголчуудын боловсролын философи үндэслэлийг судлахдаа уламжлалт арга барил дээр тулгуурлан авч үзлээ. Тэдний үр хүүхдээ хөдөлмөрт бэлтгэж ирсэн уламжлалт туршлагыг

судалж үзэхэд манай ард түмэн өдөр тутмын амьдралдаа тулгуурласан хүн төлөвшлийн гүн ухаан нь өөрийн гэсэн арга техниктэй байжээ. Монголчуудын хүн төлөвшүүлж ирсэн боловсролын философи үндэслэл нь дээр дурьдсанчлан эхний үедээ хүнийг байгалийн нэг хэсэг болохын хувьд түүний хүрээнд амьдарч, түүнийг хамгаалан хөгжүүлж, өөрөө хөгждөг, хүнийг нийгмийн тогтсон ёсонд нийцүүлэн төлөвшүүлэхэд чиглэж байсан байна. Харин социалист нийгмийн байгуулалтын үед Марксист Ленинист философид үндэслэсэн бие хүнийг өв хүмүүжүүлэх боловсролын тогтолцоотой байсан бөгөөд энэ үеийн хүн төлөвшүүлэх философи үндэслэл нь нийгмийн ба хувийн сонирхлыг хослуулж чаддаг, эх оронч, социалист үзэлтэй бие хүн төлөвшүүлэхэд чиглэгдэж байжээ. Угийн монголчууд хэзээнээс нааш үр хүүхэд, залуу хойч үеэ сурган хүмүүжүүлж, амьдралд бэлдэж ирсэн уламжлалтай, түүнийхээ философи үндэслэл нь болдог мэдлэг ухааны өв сантай ард түмэн. Хүүхдэд нэгд, ажил хөдөлмөрийн буюу амьдрал ахуйгаа авч явах, хоёрт, бусадтай харилцан нийгмийн гишүүн байх, гуравт, гэр бүл зохион, үр хүүхдээ өсгөн сургаж, хүмүүжүүлэх гэсэн гурамсан мэдлэг, ур чадварыг эзэмшүүлдэг эрин зууныг туулан амьдралаар шалгагдсан боловсролын философитой байжээ хэмээн үзэж болох юм.

#### Ашигласан материал

Ичинхорлоо Ш. 2007. *Боловсролын философи үзэл санаа эрт ба эдүгээ, 2007*). Улаанбаатар.  
Бэгз Н., Пүрэв О., Энхцогт Н, ба бусад. 2012. *Боловсролын философи*. Улаанбаатар.  
Долгорсүрэн Б. 2005. *Магистрын зэрэг*

*горилж бичсэн ажил*. Улаанбаатар.  
Саулегүл М. 2012. *Ж.Дьюгийн ардчилал ба боловсрол зохиол дахь боловсролын философийн асуудал*. Улаанбаатар.  
Дорж Д. 1998. *Монголчуудын сэтгэлгээний онцлог*. Улаанбаатар.